



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үенч сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2025/009/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2025 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас: 70432545  
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn  
Ахлах аудитор: М.Энхжаргал  
Утас: 99812792  
Цахим хаяг: Enkhjargal.m@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

**ҮЕНЧ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
М.БАТХИШИГ ТАНАА**

2025.03.21 № 2/МЧ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Үенч сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Үенч сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

**Сөрөг дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийг тооцон, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Нэгтгэлд хамрагдсан сумын Засаг даргын тамгын газарт 2024 оны санхүүгийн тайланг төрийн аудитын газарт Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ирүүлээгүй тул татгалзсан дүгнэлт гаргасан,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 20,500 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй,
- Тайлант онд ижил нэршилтэй арга хэмжээнүүдийг дугаарлаж босго үнээс бууруулж шууд гэрээ байгуулж худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас зайлсхийсэн,
- Өмнөх аудитаар өгөгдсөн 2 төлбөрийн актын 26,500.0 мянган төгрөгийн хэрэгжилтийг хангаагүй, өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй,
- Үенч сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тайлангаа хуулийн хугацаанд ирүүлээгүй хариуцлага тооцуулах албан шаардлага бичигдсэн,

- Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг ялгаатай тогтоож олгосон,
- Татварын орлого нийт дүнгээрээ 305,552,9 мянган төгрөгөөр давж биелсэн боловч татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө 58,266.5 мянган төгрөгөөр тасарсан,

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Үенч сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 1,513,675.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 305,552.9 мянган төгрөгөөр буюу 25.0 хувиар давуулан биелүүлжээ.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 702,716.8 мянган төгрөгөөр буюу 19.0 хувиар өссөн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	940,718.00	1,145,789.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	489,374.60	621,945.90
33	АВЛАГА	322,841.60	398,181.90
34	УРЬДЧИЛГАА	85,780.00	85,780.00
35	БАРАА МАТЕРИАЛ	42,721.80	39,881.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,762,359.60	3,260,004.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,762,359.60	3,260,004.90
39200	Биет хөрөнгө	2,745,841.60	3,248,486.90
39300	Биет бус хөрөнгө	11,518.00	11,518.00
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	5,000.00	
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,703,077.60	4,405,794.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	26,750.20	20,673.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,750.20	20,673.50
41300	Өглөг	26,750.20	20,673.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,676,327.40	4,385,120.90
51	Засгийн газрын хувь оролцоо	3,676,327.40	4,385,120.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,028,302.60	4,028,302.60
51101	Өмч /терийн/ /ТӨҮГ/	5,000.00	
51200	Хуримтлагдсан үр дүн	-634,097.10	79,696.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	277,121.90	277,121.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,703,077.60	4,405,794.40

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,740,929.00	4,060,955.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,117,878.60	1,499,514.80
110	Орлогын албан татвар	697,072.90	1,318,048.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	733,109.00	1,361,436.80
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-36,036.10	-43,388.90
113	Хөрөнгийн албан татвар	33,048.70	38,763.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	387,757.00	142,703.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	298,601.50	773,693.90
120	Нийтлэг татварын бус орлого	298,601.50	773,693.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,324,448.80	1,787,746.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,192,722.50	3,351,797.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,192,722.50	3,351,797.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,189,610.50	3,325,903.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471,501.60	784,855.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,049.00	97,413.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,602.80	712,404.20
2104	Хангамж, бараа материалын зардал	823,713.20	1,214,524.90
2105	Нормативт зардал	2,431.50	553.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,669.50	30,988.50
2107	Томилголт, зочны зардал	15,336.00	16,570.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	513,165.70	78,225.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	255,141.20	390,369.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,112.00	25,894.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	548,206.50	709,157.50
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	548,206.50	709,157.50

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,505,292.80	3,359,004.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,117,878.60	1,499,514.80
110	Орлогын албан татвар	697,072.90	1,318,048.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	733,109.00	1,361,436.80
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-36,036.10	-43,388.90
113	Хөрөнгийн албан татвар	33,048.70	38,763.90
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	33,893.40	35,237.30
1181	Газрын төлбөр	246,902.80	15,346.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	106,960.80	92,119.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,965.30	95,892.20
120	Нийтлэг татварын бус орлого	62,965.30	95,892.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,324,448.80	1,763,597.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,278,326.50	1,926,984.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,278,326.50	1,926,984.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,275,214.50	1,901,090.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471,569.80	783,442.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,240.30	98,122.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,819.60	712,404.20
2104	Хангамж, бараа материалын зардал	53,229.30	71,058.80
2105	Нормативт зардал	502.2	553.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,324.00	30,988.50
2107	Томилолт, зочны зардал	15,156.00	16,570.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	517,668.60	52,099.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,704.60	135,851.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,112.00	25,894.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,226,966.30	1,432,019.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	836,632.80	1,227,131.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	836,632.80	1,227,131.60
2200	Дотоод эх үүсвэрээр	836,632.80	1,227,131.60
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-836,632.80	-1,227,131.60
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-100	-72,316.90
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100	72,150.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		166.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	390,233.60	132,571.20
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	99,141.10	489,374.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	489,374.60	621,945.90

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,117,680.00	3,117,680.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,861.30	12,861.30
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,130,541.30	3,130,541.30
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,420.40	-2,420.40
9	Тайлант үеийн үр дүн	548,206.50	548,206.50
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,676,327.40	3,676,327.40
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,676,327.40	3,676,327.40
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,636.00	4,636.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,680,963.40	3,680,963.40
19	Тайлант үеийн үр дүн	704,157.50	704,157.50
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,385,120.90	4,385,120.90

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,428,488.70	3,115,854.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,823,170.50	1,816,572.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,797,276.50	1,790,678.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	784,983.00	783,442.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,122.90	98,122.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	715,961.50	710,904.17
2104	Хангамж, бараа материалын зардал	45,702.60	45,702.60
2105	Нормативт зардал	553.70	553.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,488.50	26,488.50
2107	Томилолт, зочны зардал	16,570.10	16,570.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,339.40	40,339.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,554.80	68,554.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,894.00	25,894.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,894.00	25,894.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	110,672.00	72,150.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,428,488.70	3,297,797.03
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,903,156.70	3,216,066.01
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	525,332.00	81,731.02
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31	31
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	31	31

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,692.05	121,885.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,692.05	121,885.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35,542.80	110,412.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7696.2	1,500.00
210302	Түлш, халаалт		1,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,696.19	25,356.24
210401	Бичиг хэрэг		3,900.00
210402	Тээвэр, шатахуун	7696.19	21,456.24
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500.00	4,500.00
210604	Урсгал засвар	4,500.00	4,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,059.00	11,759.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,059.00	11,759.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,917.61	67,296.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,917.61	67,296.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,149.25	11,473.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,149.25	11,473.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	24,149.25	11,473.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,692.05	121,885.24
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,692.05	121,885.24
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,670.89	86,584.99
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,855.20	11,151.00
131104	Төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	13,165.96	24,149.25

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар Сум хөгжүүлэх сан болон ОНХС-тай холбоотой нийт 132,860.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> зөрчил илэрснээс аудитын явцад 52,360.5 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- ОНХС-гийн авлагыг 38,426.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг 13,933.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Залруулагдаагүй нийт 138,766.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их, Нэгтгэлд хамрагдсан сумын Засаг даргын тамгын газарт 2024 оны санхүүгийн тайланг төрийн аудитын газарт Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ирүүлээгүй тул татгалзсан дүгнэлт гаргасан зэргийн нөлөөллийг тооцон "Сөрөг" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 138,766.5 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 138,766.5 мянган төгрөгийн 6 заалт бүхий зөвлөмж бичлээ.

### 5.1 Зөвлөмж

#### 5.1.1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй дэд хөтөлбөрүүд баталсан Үүнд: Төрийн захиргааны албан хаагчдыг чадваржуулах, Боловсрол, соёл, спортын салбарын дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангах, Ёслол хүндэтгэлийн өргөө, ЗДТГ-ын гал тогооны хэрэгсэл тохижилт, Төрийн бүтээмжийг сайжруулах чиглэлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангах, Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангах, Бүх багийн иргэдэд эрүүл мэндийн эрт илрүүлэг зохион байгуулах, Болзошгүй эрсдэлийн зардал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал, Эрүүл мэндийн салбарын үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах, Тагнуулын байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хөтөлбөр баталж байгаа хэдий ч хөтөлбөрийн үр дүнг тооцдоггүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4. "Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй", ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.4. "Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ",

Өгсөн зөвлөмж: *Илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх. Хөтөлбөр арга хэмжээ нэрийн дор урсгал үйл ажиллагааг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоож хөтөлбөрийн хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийг тооцон ажиллах,*

#### 5.1.2 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ОНХС-ын хөрөнгөөр бэлтгэсэн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэх 20,5 00 мянган төгрөгийн үнэ бүхий 9 нэр төрлийн малын мах сүү шинжлэх РН тодорхойлогч, газар тариалангийн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй, эд хөрөнгийн тооллого хийж тооцоо бодоогүй байгаа зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүргийг хүлээнэ", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусгаан илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгийн асуудлыг сумын ИТХ-ын шийдвэр гаргуулж дараа оны санхүүгийн тайланд хөрөнгөд бүртгэх

### **5.1.3. Татварын орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант онд төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого төлөвлөсөн хэмжээнээс 281,146.5 мянган төгрөгөөр давж биелснээс үүдэн татварын орлого нийт дүнгээрээ 305,552.9 мянган төгрөгөөр давж биелсэн боловч бусад татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө 58,266.5 мянган төгрөгөөр тасарсан зөрчил дутагдал нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.2.2.-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх", 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 -д "Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн орлогыг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлэн ажиллах .

### **5.1.4 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгөөр " Унагалдай" экскаватор нийлүүлэхээр ХАА зарлагдсан ажлын даалгаварт 2008 оноос доошгүй гэсэн байхад 1999 оны экскаватор нийлүүлсэн мөн Үенч сумын хөх үзүүр буюу 5-р багт иргэдийн оролцоотой 60,000 мянган төгрөгийн зам засах Босго үнээс давсан ажлуудыг задалж худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр 60,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж ажил гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлуулах саналыг сумын ИТХ-д оруулахдаа зориулалт болон хүчин чадал, нэршил, байршил нь ижил арга хэмжээг нийт дүнгээр нь батлуулан хуулийн хүрээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх.

### **5.1.5 Цалингийн бүртгэл болон төрийн сангийн хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга болон мэргэжилтэн нь орон нутгийн нэмэгдлийг 60 хувиар, бусад төрийн албан хаагчид нь 50 хувиар авч байгаа мөн сумын ОНХС-аас иргэнтэй гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн боловч зарлагын гүйлгээг өөр иргэний дансанд болон иргэний компанийн дансанд шилжүүлсэн байхад уг зарлагын гүйлгээг хянан баталгаажуулсан байгаа нь Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтын 2.3-д "Орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны, үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусгаан шийдвэрлэж болно", 2.5-д "Орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно", Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.10-т "төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3

өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ИТХ болон ЗДТГ-ын ажилчдын орон нутгийн нэмэгдлийг жил түвшинд болгож 1 ажилтанд давуу байдал үүсгэдэг байдлыг таслан зогсоох, төрийн сангийн хяналт сайжруулах.

#### **5.1.6 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө, зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр," гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг үнэн зөв байршуулан Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 07 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сум хөгжүүлэх сан	1	13,933.9	1	13,933.9			1	13,933.9				
ОНХС	-	-	1	38,426.6				38,426.6				
Дүн	1	13,933.9	2	52,360.5	-	-	1	52,360.5	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга		Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:											
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12					
ОНХС	Үндсэн хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй	1	20,500.00					1	20,500.00							
ТТЗ	Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө тасарсан	1	58,266.50					1	58,266.50							
	Төрийн албан хаагчийн орон нутагт ажилласны нэмэгдлийг ялгаатай тогтоож олгосон мөн төрийн сангийн гүйлгээнд хяналт хэрэгжүүлээгүй	1	0					1	0							
<b>Нийт дүн</b>		<b>3</b>	<b>78,766.50</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>3.00</b>	<b>78,766.50</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>					

6.3 Санхүүгийн тайлангийн аудитын нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл  
/Мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
ОНХС	Хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн шалгуур тооцдоггүй	1	0.00					1	0.00				
	Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө, зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй	1	0.00					1	0.00				
	Худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас зайлсхийж төсөл арга хэмжээг жижиглэн батлуулж санхүүжүүлсэн	1	60,000.0						1	60,000.0			
	<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>60000.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>60000.0</b>	<b>0</b>	<b>0</b>		